



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2012 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 95

Мандалговь

Орон сууц худалдах тухай

Монгол улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2, Монгол улсын төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 заалт, Монгол улсын орон сууц хувьчлах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журмын 3 дугаар зүйлийн 3.2,6.а дугаар заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн ЗДТГ-ын эзэмшилд байгаа 8 айлын орон сууцыг худалдах тухай 2010 оны 10 сарын 27 ны өдрийн 93 тогтоол гарснаас хойш 1 жил 9 сарын хугацаа өнгөрсөн боловч тухайн байранд оршин суугчид өдийг хүртэл мөнгийг төлж барагдуулаагүй байгаа учир 8 дугаар сард багтаан Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд байрны худалдах мөнгийг төвлөрүүлэх, эс төвлөрүүлсэн этгээдийн сууцыг дуудлага худалдаагаар худалдан борлуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга О.Чулуунбатад үүрэг болгосугай.

Хоёр. Оршин суугчдын гаргасан өрөгдөл хүсэлтийг харгалзан үзэж 2011 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 232 тоот тогтоол гаргаж үнийг бууруулан нийтдээ 119,7 сая төгрөгөөр худалдах шийдвэр гарч ондоо багтаан үнийг барагдуулахыг үүрэг болгосон боловч оршин суугчид орон сууц хувьчлах тухай хуулийн 20.3-т зааснаар хугацааг сунгах хүсэлт гаргасны дагуу үнийг төлөх хугацааг сунгаж өгсөн боловч шийдвэр гарснаас хойш 9 сарын хугацаа өнгөрөхөд нэгч этгээд уг шийдвэрийг хэрэгжүүлээгүй тул сунгасан хугацааг хүчингүй болгосугай.

Гурав. Худалдагдсан орон сууцыг хөрөнгийн бүртгэлээс хасахыг ЗДТГ-ын дарга О.Чулуунбатад даалгасугай.

ДАРГА

Ц. МӨНГӨНЦООЖ

010000589

17